



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/588

Улаанбаатар хот

Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх  
тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 11 дүгээр зүйлийн 11.5.7, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улсын бүртгэлийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай болгох зорилгоор нийслэл, аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэмжээнд “Иргэний бүртгэлийн чиглэлээр олгох лавлагааны төрөл”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хавсралтад дурьдсан лавлагааг 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн олгосугай.

3. Иргэний бүртгэлийн лавлагааг олгоход баримтлах чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Улсын бүртгэлийн төв архивын газрын дарга С.Оюунгэрэл, Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбат нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гантөмөр болон нийслэл, дүүрэг, аймгийн Улсын бүртгэлийн газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ДЭЛГЭРСАЙХАН



ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР ОЛГОХ  
ЛАВЛАГААНЫ ТӨРӨЛ

1. Төрсний бүртгэлийн
2. Гэрлэлтийн бүртгэлийн
3. Гэрлэлт цуцалсан бүртгэлийн
4. Эцэг /эх/ тогтоосны бүртгэлийн
5. Овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэлийн
6. Үрчлэлтийн бүртгэлийн
7. Нас барсны бүртгэлийн
8. Иргэний үнэмлэхийн
9. Гадаад паспортын
10. Төрөл садан /эцэг, эх, ах, эгч, дүү, эмэг эх, өвөг эцэг/-гийн
11. Гэрлэсэн эсэх
12. Регистрийн дугаар өөрчилсний
13. Төрсний бүртгэлгүйн
14. ХААТР-1